



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны эхний хагас жил

Агуулга




ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС



- Компанийн ерөнхий тойм**
 - Эрхэм зорилго
 - Үнэт зүйлс, Алсын хараа
 - Ажиллах хүчний нөөц
- 2023 оны Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө**
- 2023 оны Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт**
- Санхүүгийн тайлан**
- Тогтвортой байдал**
 - Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
 - Нийгмийн хариуцлага





ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС

БИДНИЙ ТУХАЙ

“ЭРҮҮЛ ХҮНС ТАНЫ СОНГОЛТ”

“Талх Чихэр” ХК өдгөө талх, талхан бүтээгдэхүүнийг 24 цаг тасралтгүй үйлдвэрлэх 6 шугам, нарийн боов үйлдвэрлэлийн 5 шугам, жигнэмэг, чихрийн шугам бүхий “Томбат” ХХК, бялуу, бэйкери төрлийн нандин бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Хотол” бялууны үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж, өдгөө 39 жилтэйгээ золгожээ.

Энэ хугацаанд бид АНУ, БНЧУ, БНСУ, Итали, Франц, Герман, Голланд, Испани, Финланд, Австари гэх мэт улстай гадаад харилцаагаа тэлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн автомат тоног төхөөрөмж, урсгал шугамыг салбартаа нэвтрүүлж, бусдаас тэргүүлэх зэргийн үйлдвэр болж үйл ажиллагаагаа улам өргөжүүлсээр байна.



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮЛ ХҮНС **1984** ТАНЫ СОНГОЛТ
ОНООС



Эрхэм зорилго

Бид олон улсын чанарын стандартад нийцсэн дэвшилтэт технологиор бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж, хэрэглэгч харилцагчдынхаа сэтгэл ханамжинд үнэлэгдсэн хүнсний салбарын загвар компани байна.



ТАЛХ ЧИХЭР ХК

ЭРҮҮА ХҮНС 1984 ТАНЫ СОНГОЛТ
ОНООС

Алсын хараа

Хувьсан өөрчлөгдөх хэрэглээний соёлыг тодорхойлон, нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгэмд үнэ цэнэ бүтээгч, хүн төвтэй байгууллага байна.

Үнэт зүйлс

- Т** - Тэргүүн технологи
- А** - Аюулгүй бүтээгдэхүүн
- Ч** - Чадварлаг ажилтан
- И** - Итгэлцэл, түншлэл

Ажиллах хүчний нөөц

Нийт ажилтан



915

Тогтвортой ажлын байрны өсөлт



5,4%



503

Эмэгтэй



412


Эрэгтэй


Ажилтнуудын дундаж нас 71%





20-45 нас


✓ Бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө

- 

1 “ISO 22000:2018” ХАБМТ-ны стандарт дээр тулгуурлан үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор “FSSC 22000” – хүнсний аюулгүй байдлын схем, хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, баталгаажуулалт үнэлгээг хийлгэнэ.
- 

2 “MNS ISO 45001:2018” ХЭМАБМТ-ны стандартын үнэлгээ, баталгаажуулалтыг хийлгэж, үйл ажиллагаандаа нутагшуулан, сургалт хөгжүүлэлтийг тогтмолжуулж, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт /KPI/ -р үнэлэх системийг сайжруулна.
- 

3 Бялуун төрлийн бүтээгдэхүүний шинэ тренд бий болгож, Хэвтэй талхны шугамыг бүрэн автоматжуулан хүчин чадал болон нэр төрлийг 30-40%-иар, Давхраат болон Хөмөл бүтээгдэхүүний нэр төрлийг 50%-иар, Монголын үндэсний тавгийн идээний боовны нэр төрлийг 10%-иар тус тус нэмэгдүүлнэ.
- 

4 Техник, тоног төхөөрөмжийн засварын нөөц бүрдүүлж, мэдээллийн сан үүсгэх, уламжлалт чаналгын бүтээгдэхүүн үндсэн дамжлага / хивлэгээ, бэмбий/-г механикжуулж, гар ажиллагааг 20%-иар багасгах, “Багет” ,” Чиабатта” талхны шугамыг бүрэн автоматжуулсан хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 

5 Сонирхогч талууд болон хэрэглэгчийн сэтгэл хангамжийн хэрэгцээ, шаардлагыг судлан, сэтгэл ханамжийн түвшин 8%-иар дээшлүүлж, Зах зээлд шинээр нийлүүлсэн бүтээгдэхүүний борлуулалтыг 10%-иар өсгөнө.


✓ 2023 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

1



“ISO 22000:2018” ХАБМТ-ны стандарт дээр тулгуурлан үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор “FSSC 22000” – хүнсний аюулгүй байдлын схем, хүнсний чанар, хүнсний хамгаалалт, хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлэх ажиллагааг хамарсан иж бүрэн менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж, баталгаажуулалт үнэлгээг хийлгэнэ.

FSSC 22000 – Хүнсний аюулгүй байдлын баталгаажуулалтын иж бүрэн тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилт тавьж, 2023 оны 03-р сараас эхлэн баг бүрдүүлэн FSSC 22000 –г сургалтад хамрагдаж, сертификат авсан. Олон улсын “TUV AUSTRIA”-н баталгаажуулалтын байгууллагаар 2023 оны 10-р сард аудит орохоор санал тавьсан.



2

“MNS ISO 45001:2018” ХЭМАБМТ-ны стандартын үнэлгээ, баталгаажуулалтыг хийлгэж, үйл ажиллагаандаа нутагшуулан, сургалт хөгжүүлэлтийг тогтмолжуулж, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт /KPI/-р үнэлэх системийг сайжруулна.

- *Сургалт хөгжүүлэлт: Компанийн хэмжээнд бүх ажилчдыг хамруулан гадаад болон дотооддоо сургалт хөгжүүлэлтийг тогтмол хийх, бүх ажилтныг хамруулж байна.*
- *ISO 45001:2018 стандартын баталгаажуулалтыг 08-р сард хийж, аудитанд орно.*
- *Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, орчин нөхцлийг сайжруулан мэргэжлийн байгууллагаар Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.*



3



Бялуун төрлийн бүтээгдэхүүний шинэ тренд бий болгож, Хэвтэй талхны шугамыг бүрэн автоматжуулан хүчин чадал болон нэр төрлийг 30-иас 40%-иар, Давхраат болон Хөөмөл бүтээгдэхүүний нэр төрлийг 50%-иар, Монголын үндэсний тавгийн идээний боовны нэр төрлийг 10%-иар тус тус нэмэгдүүлнэ.

- 2023 оны 05-р сарын 20-29 хооронд 12 хүний бүрэлдэхүүнтэй Шанхайн үзэсгэлэн “Bakery China”-д оролцон бүтээгдэхүүний хөгжсүүлэлт, тоног төхөөрөмж, өнөөгийн чиг хандлага, түүхий эдийн чанарыг сайжруулах, бүтээгдэхүүний шинэлэг байдлыг алдагдуулахгүй сав баглаа боодлыг судалж, энэхүү чиглэлийн ханган нийлүүлэгч байгууллагуудтай гэрээ хийж, хамтран ажиллахаар болсон.
- Давхраат, хөөмөл, уламжлалт тавгийн идээний хэвийн боовны нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дотооддоо туршилт, тохируулгын ажил хийн ажиллаж байна.



4



Техник, тоног төхөөрөмжийн засварын нөөц бүрдүүлж, мэдээллийн сан үүсгэх, уламжлалт чаналгын бүтээгдэхүүн үндсэн дамжлага / хивлэгээ, бэмбий/-г механикжуулж, гар ажиллагааг 20%-иар багасгах, “Багет” ,” Чиабатта” талхны шугамыг бүрэн автоматжуулсан хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

- *Үйлдвэрийн тасралтгүй үйл ажиллагааг сайжруулж, хангахын тулд тоног төхөөрөмжийн засварын нөөцийг бүрдүүлэн, Олон улсын Итали, БНХАУ-н дэвшилтэт тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг байгууллагуудтай хамтарч, туршилт судалгаа хийн, тоног төхөөрөмжийн шинэчлэлт сайжруулалтын ажлыг гүйцэтгэв.*
- *Төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхийн тулд Итали улсын Риминий хотод “Siger”- үзэсгэлэнд 2022.01-01/31-нд 9 хүний бүрэлдэхүүнтэй оролцож, Cери ,Costal, Beor, Daxher зэрэг байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцан, сургалтад хамрагдаж Costal , Beor –р байгууллагатай хамтын гэрээ хэлэлцээр хийн, тоног төхөөрөмжийн захиалга хийгдсэн.*
- *Механик цехийн тоног төхөөрөмж, гурилын системийг сайжруулах судалгааг хийж, Тайвань улсын дэвшилтэт тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг Spon, Shelly –зэрэг байгууллагын үйл ажиллагаатай танилцан туршилага судалсан.*
- *Үйлдвэрийн агааржуулалтын системийг сайжруулах зорилгоор БНХАУ-н Hisense –тэй хамтран ажиллах гэрээг хийн баталгаажуулж, мэргэжилтэнг урин үйлдвэрийн агааржуулалтын системд сайжруулалтыг хийж эхэлсэн.*



5



Сонирхогч талууд болон хэрэглэгчийн сэтгэл хангамжийн хэрэгцээ, шаардлагыг судлан, сэтгэл ханамжийн түвшин 8%-иар дээшлүүлж, Зах зээлд шинээр нийлүүлсэн бүтээгдэхүүний борлуулалтыг 10%-иар өсгөнө.

- *Ажилчдын цалинг 30%-иар нэмэгдүүлсэн.*
- *Мэргэжлийн байгууллагатай хамтран Анхан тусламжийн сургалт, дадлагыг зохион байгуулан бүх ажилчдад мэдлэг ойлголт өгсөн.*
- *Бүх ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан ба мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс компанийн эмч, сувилагч нар өдөр бүх ажилчдын эрүүл мэндийн үзлэг хийж байна.*
- *Ажилчдын сэтгэл ханамжийн судалгааг хийж, санал хүсэлтийг тодорхойлон, цаашид сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.*





Өнөд оршихуйн дархлаа “Язгуур” брэнд

Цагаан сар бол Монгол туургатны уламжлагдан үлдсэн баяр юм. Үндэстэн ястан бүр тавгийн идээгээ өөр өөрөөр засдаг. Тиймээс бид хэрэглэгчийн сонголтыг нэмж, “ЯЗГУУР” брэндийн ЗҮСЭЛТТЭЙ ХЭВИЙН 15 болон 25ш савалгаатай худалдаанд гаргасан.



Борлуулалтын үйл ажиллагаа

Хэрэглэгчдэд компанийн танигдалтын түвшинг өсгөх, хоногшуулах зорилгоор түгээлтийн машин болон нэрийн барааны өнгө төрхийг шинэчилсэн.



Аз жаргалын гэрч “Хотол” брэнд

Бялуу гэдэг бүтээгдэхүүн өөрөө ямар ч онцлох баярыг илэрхийлэх онцгой бүтээгдэхүүн юм. Иймээс бид баяр бүрийг онцгой хэмээн үзэж, сар ишний баярт зориулан онцгойлон чимэглэл хийж, маркетингийн идэвхжүүлэлтээр дамжуулан хэрэглээний соёлыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.



Хэзээ ч хаана ч өөрийнхөөрөө “Хаан” брэнд

Бид хэрэглэгчийн сегмент бүрт тохирсон бүтээгдэхүүн үйлдвэрлэн, брэнд идэвхжүүлэлтийн ажлыг сошиал маркетингийн суваг ашиглан хэрэглэгчдэд хүргэн ажиллаж байна.



59,7 ТЭР БУМ
НИЙТ БОРЛУУЛАЛТЫН
ОРЛОГО



5,4 ТЭР БУМ
УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН
ОРЛОГОД

“Талх Чихэр” ХК нь 2023 оны эхний хагас жилд **59,7** тэрбум төгрөгийн борлуулалт хийж, урьд оны энэ үеэс орлого **15.1** тэрбум төгрөгөөр буюу 25.3%-р өссөн байна. Улсад орлогын татвар 977,5 сая төгрөг төлсөн. Монгол улсын нэгдсэн төсвийн орлогод 5,4 тэрбумыг төвлөрүүлсэн.

СУРГАЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ

Ажилчдыг сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг дотоод нөөц бололцоогоор тогтмол хийж хэрэгжүүлсэн. Мөн олон жил ажилсан болон оны шилдэг ажилчдаа үнэлэн гадаад туршлага судлуулах зорилгоор олон улс уруу явуулсан. Нийт 11 чиглэлийн сургалтад 507 ажилчид хамрагдсан.

- Галын аюулгүй байдал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
- ISO 45001:2018 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандарт нэвтрүүлэх, ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо
- Гадаад мэргэжилтэн болон зөвлөх инженерийн технологи болон тоног төхөөрөмжийн сургалт, Тусгай ур чадвар олгох сургалт
- Хувь хүний хөгжлийн сургалт, Шинэ ажилтны танилцуулах сургалт



УРАМШУУЛАЛ

Оффисын болон үйлдвэрийн дундаас дээш түвшний ажилтнуудад ажлын үнэмлэх, лого бүхий хувцас олгож эхэлсэн. Ажилтан бүрийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогын хүрээнд цалин, урамшуулал нэмэгдүүлсэн.

- Спортын шигшээ багийн тамирчдадаа ур чадварын нэмэгдэл
- Тогтвортой ажилласан жилийн нэмэгдэл
- Гүйцэтгэлийн үнэлгээгээр урамшуулал
- Хөдөлмөрийн аварга урамшуулал
- Түлхүүр ажилчдын урамшуулал

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Ажилтан бүрийг тогтвор суурьшилтай ажиллах боломж бүрдүүлэх үүднээс спортын тэмцээн, урлагийн наадам, аялал, шагнал урамшуулал зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.



ТОГТВОРТОЙ АЖИЛЛАСАН ЖИЛИЙН НЭМЭГДЭЛ

САР БҮРИЙН АЖИЛЛАСАН ЦАГИЙН БАЛАНСЫГ ҮНДЭСЛЭН ДАРАА САРЫН 25-НЫ ОДОР ОЛГОГДОНО.

Ажлын жил	Нэмэгдэл (₮)
1-3 жил	80.000₮
4-8 жил	100.000₮
9-15 жил	130.000₮
16-аас дээш жил	150.000₮

Нийгэмлэгийн жилжиг тусгаарлагдмал хувьцааг үнэмлэхүй хэргээр /өвчлэл, мөнгөтэй, шалтгаангүй, гурвалцаа /ахлаас тэр хөнгөлөгдөж байж олгохдоо орсон /2018.01.01-нээ өдрөөс өмнө/ ажилтны хөлболог баримт бичгийг үндэслэн ахлаас өмчлөгчид хувиар эзлэж, өөрсөнд олгох орон ах сар адрөөр илэн тооцно.

Өөрийн хувиар, санхүүг зөвлөж ахлаас чөлөөтэй бүхэл болон Шинээр охиод орсон ажилчдын ажилласан жилийг зөвхөн сүүлд орсон ох сар адрөөр тооцно.

Цаашд 2018.01.01-нээ өдрөөс хойш орсон ажилчдын ажилласан жилийг зөвхөн сүүлд орсон ох сар адрөөр тооцно.

- Мөнгөтэй:** Төрийн сарын нэр 90% -ийг өмнө байх үзвэл өөрөөр өмнө ажиллаж тооцно!
- Хувиар:** Үндэслэн ажилласан ажилтны ажилын жилд ажилласан жилд өөрсөнд олгохдоо орсон ах сар адрөөр тооцно.
- Гурвалцаа:** Түр хувиар ажилласан ажилтны өөрсөнд олгохдоо орсон ах сар адрөөр тооцно!



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Хэрэглэгчдийн эрүүл мэнд, байгаль орчин, нийгэмд эерэг сэтгэгдэл үлдээх зорилгын хүрээнд хамтрагч байгууллага, ажиллагсдынхаа өмнө хүлээх үүрэг хариуцлагаа өдөр тутмын үйл ажиллагаандаа тусган ажилдаг нийгмийн хариуцлагатай компани юм.

БААТРУУДААРАА БАХАРХЪЯ

"Талх Чихэр" ХК жил бүрийн сар шинийн баярын өмнө Хөдөлмөрийн баатруудаараа бахархан хүндэтгэл үзүүлж, алдаршуулдаг уламжлалтай.

Уг уламжлалын дагуу малчны хот, хөнгөн үйлдвэрийн цех, уул уурхай, урлаг, спорт гээд бүхий л салбараас өөрийн ажил хөдөлмөр хичээл зүтгэлээ төр засаг, түмэн олноороо үнэлүүлж, төрийн их хайр хишгийг хүртсэн эрхмүүддээ хүндэтгэл үзүүлэх уг арга хэмжээг "БААТРУУДААРАА БАХАРХЪЯ" нэрийн дор 9 дахь жилдээ ийнхүү амжилттай зохион байгууллаа.



**Ахмад ажилчид
хүндэтгэлийн хүлээн авалт**



17-р жарны Үзэсгэлэнт болгогч хэмээх Харагчин туулай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан "Талх Чихэр" ХК үе үеийн алтан хэлхээ болсон ахмад ажилчдаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

"Талх Чихэр" ХК олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 900 гаруй ажилтан албан хаагчдынхаа хүүхдүүдэд гэнэтийн бэлэг барьж, "Мөрөөдөл бидний ирээдүй-Та Чи" арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээний үеэр дуучин Ч.Уранхолбоо оролцож, хүүхдүүдийн баяр дээр баяр нэмсэн бөгөөд эцэг эхчүүдийн төлөөлөл ӨНХРҮҮШ жүжгийг амилуулж, хүүхдүүд маань бөөн бөөн гэнэтийн бэлэг дүүрэн нэг өдрийг аав ээжтэйгээ өнгөрүүлсэн.

**“Мөрөөдөл бидний ирээдүй
ТА ЧИ” хүүхдийн баярын
арга хэмжээ**




АМТЛАГ АЯЛАЛ 2023

"Амтлаг аялал" нэрийн хүрээнд Улаанбаатар хотын 10 жилийн сургууль, хамтран ажиллагч байгууллагын 1000 гаруй хүүхэд багачуудад үйлдвэрийнхээ үйл ажиллагааг танилцуулсан байна. Аялалд оролцсон хүүхэд бүртээ бид #Амтлаг брэндийнхээ бүтээгдэхүүний дээжийг бэлэглэсэн билээ.

Мөн БГД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран Зэвсэгт хүчний 120-р ангийн бие бүрэлдэхүүний төлөөлөл шинэхэн Атар талх, Та Чи нарийн боов, Delice pastry брэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй үйл ажиллагаатай танилцсан.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Монголын ардчилсан холбоо, "Genco Tour Bureau" ХК-тай хамтран зохион байгуулсан аяллын хүрээнд Улаанбаатар хот, 21 аймгийн 300 гаруй хүүхэд багачууд үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай танилцсан.



Баялаг бүтээгч-Business

Үндэсний үйдвэрлэгчдийн "Баялаг бүтээгч-Business" тур 4 дэх удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж, 50 гаруй үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөлөл "Талх Чихэр" ХК-ийн үйл ажиллагаатай танилцсан. Тэр дундаа талх, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч "Алиман сар" ХХК, "Өгөөж чихэр боов" ХХК, "Жинтуул" ХХК, "Батбайгаль" ХХК, "Тэнгэрийн хишиг" ХХК зэрэг аж ахуй нэгжүүд туршлага солилцох зорилгоор ийнхүү хүрэлцэн ирсэн нь бидний хувьд нэр төрийн хэрэг юм.



“ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА”



"Талх Чихэр" ХК нийгмийн хариуцлагын хүрээнд СХД-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин СХД-ийн ЗДТГ, Нийгмийн хөгжлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл сургалтын төвтэй хамтран “ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА” зохион байгуулсан.

Монголын уртын дууны холбооны 20 жилийн ой, Уртын дууны "Өнө" чуулгын 10 жилийн ойг тохиолдуулан Азийн хотуудын ардын урлаг, гар урлалын "Asia Folk-2023" наадмын хүрээнд монголын үе үеийн төлөөлөл болсон 300 уртын дуучин нэг дор чуулж, ургах нарыг уртын дуугаараа угтсан түүхэнд бичигдэх гайхалтай үйл явдлыг дэмжин, хамтран ажилласан билээ.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Ардын урлагаа дэмжигч “Талх Чихэр” ХК



Анхаарал хандуулсанд баярлалаа

*БИДЭНТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХАД БИДНИЙ
ҮҮД ХААЛГА ҮРГЭЛЖ НЭЭЛТТЭЙ*

Phone:

976- 7288-8888

Email:

info@talkh-chikher.mn

marketing@talkh-chikher.mn